

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар  
Улаанбаатар хот  
сарын ...ны өдөр

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ  
НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

**1/ 11<sup>1</sup> дүгээр зүйл:**

**"11<sup>1</sup> дүгээр зүйл. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

11<sup>1.1</sup>. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлд заасан үүргээ барьцаалан зээлдүүлэх газар биелүүлээгүй, зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгуулахтай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11<sup>1.1.1</sup>. албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулах;

11<sup>1.1.2</sup>. энэ хуулийн 11<sup>1.1.1</sup>-д заасан албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хуулийн этгээдийн улсын бүртгэлээс Барьцаалан зээлдүүлэх газрын үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг хасуулахаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандах.

11<sup>1.2</sup>. Улсын бүртгэлийн ерөнхий газар нь энэ хуулийн 11<sup>1.1.2</sup>-т заасныг үндэслэн Барьцаалан зээлдүүлэх газрын үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасна."

**2/ 14<sup>1</sup> дүгээр зүйл:**

**"14<sup>1</sup> дүгээр зүйл. Барьцаалан зээлдүүлэх газар болон Зээлдэгч хоорондын зээлийн гэрээний харилцааны хүрээнд авах арга хэмжээ**

14<sup>1.1</sup>. Барьцаалан зээлдүүлэх газар нь Зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хамаарах хүүгийн хэмжээг сарын 3 /гурав/ хувиас, алдангийг 0.2 (тэг бүхэл хоёр) хувиас тус тус хэтрүүлэхгүй тооцно.

14<sup>1.2</sup>. Энэ хуулийн 14<sup>1.1</sup>-д заасан зээлийн гэрээний хугацаанд бусад нэмэгдүүлсэн хүү, шимтгэл, хураамж тооцохгүй.

14<sup>1.3</sup>. Барьцаалан зээлдүүлэх газар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

14<sup>1</sup>.3.1.зээлийн гэрээнд энэ хуулийн 14<sup>1</sup>.1-д заасны дагуу өөрчлөлт оруулах үүрэгтэй бөгөөд өөрчлөлттэй холбоотой мэдээллийг боломжит арга хэрэгслийг ашиглаж Зээлдэгчид мэдэгдэх;

14<sup>1</sup>.3.2.зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, зээлийн төлбөр, хүү төлөх хуваарийг шинэчлэн Зээлдэгчид мэдэгдэх;

14<sup>1</sup>.4.Барьцаалан зээлдүүлэх газар энэ хуулийн 14<sup>1</sup>.1-д заасан хугацаанд бусад нэмэгдүүлсэн хүү, шимтгэл, хураамж тооцох болон 2020 оны 11 дүгээр сарын 12-ний өдрөөс хойш гэрээ байгуулж 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар гэрээ хүчин төгөлдөр үйлчилж буй зээлдэгчийн болон 2021 оны 6 дугаар сарын 30-ний өдөр хүртэлх хугацаанд байгуулсан зээлийн гэрээний барьцаалуулсан хөрөнгийг 2021 оны 7 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангах арга хэрэглэхийг хориглоно.

14<sup>1</sup>.5.Зээлдэгч нь энэ хуульд заасны дагуу гэрээнд өөрчлөлт оруулахыг Барьцаалан зээлдүүлэх газраас шаардах эрхтэй.

14<sup>1</sup>.6.Зээлдэгч энэ хуулийн 14<sup>1</sup>.1, 14<sup>1</sup>.2-д заасны дагуу тухайн хугацаанд хөнгөлөлттэй нөхцөлт зээлийн хүү, алданги төлөх эрхтэй бөгөөд бусад нэмэгдүүлсэн хүү, шимтгэл, хураамж төлөх үүргээс чөлөөлөгдөх, барьцаалан зээлдүүлэх газарт барьцаалсан хөрөнгөөрөө үүргийн гүйцэтгэлийг хангуулахгүй байхыг шаардах эрхтэй.

14<sup>1</sup>.7.Зээлдэгч нь Барьцаалан зээлдүүлэх газрыг энэ хуульд заасныг зөрчсөн гэж үзвэл Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гомдлоо гаргана.

14<sup>1</sup>.8. Зээлдэгч зээлийн гэрээний үлдэгдэл төлбөр, хүү, алданги, бусад шимтгэл, хураамжийг төлж барагдуулахад 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс өмнө Барьцаалан зээлдүүлэх газартай гэрээ байгуулсан харилцаанд энэ хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийг буцаан хэрэглэхгүй."

14<sup>1</sup>.9.Зээлдэгч барьцаалсан хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахад 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө Барьцаалан зээлдүүлэх газартай гэрээ байгуулсан харилцаанд энэ хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийг буцаан хэрэглэхгүй."

3/ 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:

"18.3.Энэ хуулийн 18.1 дэх заалтад энэ хуулийн 11<sup>1</sup>, 14<sup>1</sup>дүгээр зүйлд заасан харилцаа хамаарахгүй."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг